

Төгс эзэмших сургаал: 2-р үнэлгээний шалгалт 2—Суралцах зааварчилгаа

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Судрын эшлэл, түлхүүр үг хэллэгийг цээжлэх

Төгс эзэмших сургаалын судрын хэсэг, түлхүүр үг хэллэгийг сайн мэддэг бол. Та давтлагадаа төгс эзэмших сургаалын гар утасны аппликэйшнийг татаж аваад, ашиглаж болох юм.

1 Коринт 6:19–20	“Та нарын бие бол Ариун Сүнсний сүм.”
1 Коринт 11:11	“Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм.”
1 Коринт 15:20–22	“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно.”
1 Коринт 15:40–42	Амилалтад гурван түвшний алдар суу байдаг.
Ефес 1:10	“Цагийн дүүрлийг гүйцэлдүүлэхийн тулд ... бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ.”
Ефес 2:19–20	Сүм нь “элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ.”
2 Тесалоник 2:1–3	“Эхлээд урвалт гарахаас нааш Христийн өдөр ирэхгүй.”
2 Тимот 3:15–17	“Ариун судрууд мэргэн ухааныг чамд өгөх чадалтай.”
Еврей 12:9	Тэнгэрлэг Эцэг бол “сүнсний Эцэг.”
Иаков 1:5–6	“Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, Бурханаас гуйг.”
Иаков 2:17–18	“Итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм.”
1 Петр 4:6	“Сайн мэдээ нь үхэгсдэд ч хүртэл тунхаглагдсан.”
Илчлэл 20:12	“Үхэгсэд үйлсийнхээ дагуу ... шүүгдэв.”

Сургаалыг бодит амьдрал дээрх нөхцөл байдалд хэрэгжүүлэх

- Амьдралдаа чухал шийдвэр гаргахдаа зааварчилгаа авахыг хүсэж буй хэн нэгэнд туслахын тулд төгс эзэмших сургаалын судрын нэг эсвэл хэд хэдэн хэсгийг ашигла.
- Хэрэв та Бурханы Өөрийн хүүхдүүдэд бэлдсэн төлөвлөгөөнд үхлийн дараа хүнд юу тохиодог талаар заах бол Шинэ Гэрээний төгс эзэмших сургаалын судрын аль аль хэсгийг ашиглаж болох вэ? Та биднийг гэх Бурханы хайрыг харуулахын тулд судрын эдгээр хэсгийг хэрхэн ашиглаж болох вэ?

Төгс эзэмших сургаалын судрын аль аль хэсэг танд хамгийн их нөлөөлсөн талаар хуваалцахад бэлд. Тухайн хэсэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар танд юу заадаг вэ?

Сүнслэг мэдлэг олж авах зарчмууд

Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал (2022)-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн 5–12-р догол мөрийг эргэн харна уу.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ